



**АУДИТ ХИЙСЭН
ҮНДЭСЛЭЛ**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН НЭР: Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: ҮАГ-ГАГ-/2017/09-ГА



Баянхонгор аймгийн төрийн болон хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.

*Баянхонгор хот
2017.10.20*

АГҮҮЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
АУДИТЫН ТАЙЛАН	4
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН	6
Баянхонгор аймгийн төрийн болон хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна	6
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна.	15
Аймгийн болон сумдын ГХУСАЗЗ-үүд нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сайн зохион байгуулж, үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлж байна	17
1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас зориулалт бусаар зарцуулагдаж байна	19
АУДИТЫН ДҮГНЭЛТ	23
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	
Баянхонгор аймагт гарсан гэмт хэргийн судалгаа	24

Тайланг бэлтгэсэн:

Баянхонгор аймаг дахь
Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Ахлах аудитор

Ё.Сугаррагчаа

Аудитор

П.Мөнх-Эрдэнэ

2017 оны 10 дүгээр сарын 20

Тайланг Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын газрын

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.bayankhongor.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар

нэмж тодруулах, асууж

лавлах зүйл байвал
70442584, 70442424
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ: Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын газар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	- ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГАГ	- ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
ГА	- ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
УИХ	- УЛСЫН ИХ ХУРАЛ
ГХУСАЗЗ	-ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ
ЦЕГ	-ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИТХ	- ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ЗДТГ	- ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ШШГА	- ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА
МХГ	- МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ББМГУ	- БУСДЫН БИЕ МАХ БОДИД ГЭМТЭЛ УЧРУУЛАХ
ХАБЖЭГХ	- ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1.Аудитын нэр: Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн

2.Аудитын код: ҮАГ-ГАГ-/2017/09-ГА

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

4.Аудитын зорилт

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийв.Үүнд:

- Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх.

5.Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн ИТХ, ГХУСАЗЗ, Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар, аймгийн Прокурорын газар, ШШГА-ны 2015 он, 2016 он, 2017 оны эхний хагас жилийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хамруулан гүйцэтгэв.

6. Үндсэн мэдээлэл

Тус аймгийн хэмжээнд 2015 онд 360, 2016 онд 356, 2017 оны эхний хагас жилд 212 гэмт хэрэг тус тус гарсан байна. 2017 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн 121 буюу 57 хувь нь аймгийн төв - Баянхонгор суманд, 91 буюу 43 хувь нь бусад суманд үйлдэгджээ.

Баянхонгор аймаг нь гэмт хэргийн гаралтаараа хил залгаа орших Архангай, Өвөрхангай аймгаас 7,8-17,5 хувиар бага, Говь-Алтай, Завхан аймгаас 1,0-1,4 дахин их байна.

Тус аймагт 2015 онд 12494, 2016 онд 7741 зөрчил гарч, өмнөх оноос 38 хувиар буурсан. 2016 оны эхний хагаст 3768 зөрчил гарч байсан бол 2017 оны эхний хагас жилд 5162 зөрчил гарч, өмнөх оны мөн үеэс 37 хувиар өсчээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2015 онд 60.0 сая, 2016 онд 80.0 сая, 2017 онд 80,0 сая төгрөг тус тус төсөвлөж, ГХУСАЗЗ-ийн хурлаар хуваарилан зарцуулж байна.

7. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад цуглуулж судалсан баримт, материал, урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн, хийх аудитын ерөнхий эрсдэлийг “**Дунд**” гэж үнэлэв.

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аймгийн ЗДТГ, аймгийн ГХБХБГ-ын албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

9. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль
- Прокурорын байгууллагын тухай хууль
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

10. Аудитын хугацаа

Аудитыг 2017 оны 09-р сарын 20-ноос эхлэн гүйцэтгэж, мөн оны 10 дугаар сарын 20-ны өдөр удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 10 дугаар сарын 23-ны өдөр ҮАГ-ын ГАГ-т хүргүүлэв.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН



Зорилт 1.1 Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?



Баянхонгор аймгийн төрийн болон хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.

1.1.1 Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиг үүрэг хэрхэн хэрэгжиж байна вэ?

Баянхонгор аймгийн хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тогтоох талаар Судалгаа, дүн шинжилгээний баг хангалтгүй ажилласан байна

Тус аймгийн хэмжээнд 2015 онд 360, 2016 онд 356, 2017 оны эхний хагас жилд 212 гэмт хэрэг тус тус гарсан байна /Хавсралт №1/





2017 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн 121 буюу 57 хувь нь аймгийн төв - Баянхонгор суманд, 91 буюу 43 хувь нь бусад суманд үйлдэгджээ.

Баянхонгор аймаг нь гэмт хэргийн гаралтаараа хил залгаа орших Архангай, Өвөрхангай аймгаас 7,8-17,5 хувиар бага, Говь-Алтай, Завхан аймгаас 1,0-1,4 дахин их байна.

Зөрчлийн судалгаа

/ 2015-2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар /

№	Хамарсан хугацаа	2014 он	2015 он	Хувь / Өсөлт +, Бууралт - /	2015 он	2016 он	Хувь / Өсөлт +, Бууралт - /	2016 оны эхний хагас жил	2017 оны эхний хагас жил	Хувь / Өсөлт +, Бууралт - /
1	Нийт зөрчлийн тоо	13520	12494	-7,5	12494	7741	-38,0	3768	5162	+37,0

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн №А/110 тушаалаар Судалгаа, дүн шинжилгээний 9 хүний бүрэлдэхүүнтэй, “гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг судалж, урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж боловсруулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, үр дүн, явц байдлыг сар тутам танилцуулах” чиг үүрэг бүхий багийг байгуулжээ.

Судалгаа, дүн шинжилгээний багаас гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг сумдаар, Баянхонгор сумыг багуудаар нь, гарсан гариг, цагаар нь, гэмт хэргийн өнгөөр нь, гэмт хэрэг үйлдэгчийг нас, хүйс, нийгмийн байдлаар нь сар, улирал тутам харьцуулан судалж, дүгнэлт хийн, Криминологи судалгааны багийн хурлаар хэлэлцэн, анхаарч ажиллах асуудлын талаар холбогдох тасаг, хэсгийн дарга нарт зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна. Судалгаа, дүн шинжилгээний баг 2015, 2016 онд тус бүр 4 удаа, 2017 оны эхний хагас жилд хэсгийн байцаагч, багийн цагдаа, эрүүгийн төлөөлөгч нарыг оролцуулан өргөтгөсөн байдлаар 6 удаа хуралдуулж, гэмт хэргийн гаралт, анхаарах асуудлын талаар багийн гишүүд санал бодлоо илэрхийлж ярилаж байгаа нь сайшаалтай байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар аймгийн Цагдаагийн газраас иргэн, хуулийн этгээдэд 131 мэдэгдэл өгсөн ба зөрчлийг арилгасан талаар хариуг тухай бүр авчээ.

ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газраас ирүүлсэн статистик мэдээг үндэслэн гэмт хэрэг, зөрчлийн танилцуулга, мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын саналыг тусган сар бүр холбогдох албан тушаалтанд, улирал бүр сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт “Хариуцсан сум орон нутагтаа гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажиллах тухай” албан бичгийн хамт хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Прокурорын газраас тус аймагт үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтын байдал, Эрүүгийн нөхцөл байдлын судалгааг улирал, хагас жилээр, Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн талаархи гомдол мэдээлэл, Эмэгтэйчүүдийн үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах зэрэг нийт 4 судалгаа хийжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас ялтныг нийгэмшүүлэх ажлын хүрээнд дахин гэмт хэрэг үйлдэх, оргон зайлахаас урьдчилан сэргийлж, аймгийн Цагдаагийн газрын сэтгэл зүйчтэй хамтран улирал бүр нийт ялтан, хоригдогсдоос сэтгэл зүйн сорил авч нэгтгэж байна.

Шүүхийн тамгын газраас Баянхонгор аймаг дахь шүүхүүдийн 2016 оны мэдээ тайланг аймгийн болон 20 сумын удирдлага, аймгийн ГХУСАЗСЗ-д хүргүүлж, тэднийг мэдээллээр хангаж ажиллаж байна.

1.1.2 Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлж байна уу?

Бүх шатны ИТХ, нутгийн захиргааны байгууллага гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж, урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг батлан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд төр, захиргааны байгууллагаас бодлогын түвшинд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэсний үр дүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бодитой ахиц гарч, гэмт хэргийн тоон үзүүлэлт сүүлийн гурван жил дараалан буурч, илрүүлэлт сайжирч, олон нийтийн дунд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны ажил өргөжиж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч байна. Аймгийн ГХУСАЗСЗ-д 2015 онд 53,6 сая төгрөгийн, 2016 онд 80,0 сая төгрөгийн, 2017 онд мөн 80,0 сая төгрөгийн төсөв батлагдсан ба дээрхи хөрөнгийг төлөвлөсөн ажилдаа хуваарилан, зохицуулах зөвлөлийн хурлаар баталсан байна.

Аймгийн Цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүргүүлсэн санал, танилцуулгыг үндэслэн аймгийн ИТХ-ын болон ГХУСАЗСЗ-ийн тогтоол 4, Засаг даргын захирамж 4, хөтөлбөр 1, журам 1-ийг гарган хэрэгжүүлжээ. Тухайлбал:

- “Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг худалдан борлуулдаг цэгүүдийн цагийн хязгаарыг тогтоох журам” батлуулж, аймгийн ЗДТГ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулан Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлүүдийг шинэчлэх ажлыг зохион байгуулж, цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан.
- “Амар амгалан” дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- “Малчдын бүлэг ажиллуулах журам батлах тухай” тогтоол, “Орон сууц, гэр хорооллын гудамжийг камержуулах тухай” тогтоол, аймгийн Засаг дарга “Нийтийн эргүүл ажиллуулах тухай” захирамж, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай” захирамжийг тус тус баталсан байна.

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын криминологи судалгааны

багийн дүгнэлтийг үндэслэн тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 83 дугаар тогтоол / “Орон сууц, гэр хорооллын гудамжийг камержуулах тухай” /-ыг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн ГХУСАЗСЗ-ийн өргөтгөсөн хурлаар шийдвэр гаргуулж, орон сууц, гэр хорооллыг гудамжийг камержуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Орон нутгийн төр, захиргааны байгууллагад хандан холбогдох шийдвэр гаргуулж, камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулсны үр дүнд хөдөөгийн сум тус бүрт гудамжны 2-4 камер, аж ахуйн нэгжүүдэд нийт 123 камер тавиулж, ашиглаж байна.

Цагдаагийн газраас аймгийн ИТХ, ГХУСАЗС-д асуудал оруулж хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлснээр 2,5 сая төгрөгөөр 19 хяналтын камерийн засвар үйлчилгээг хийлгэжээ.

Баянхонгор сумын хэмжээнд Замын сангийн хөрөнгө болон орон нутгийн төсвөөр хийгдэх ажлын жагсаалтанд Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас санал оруулснаар автозамын тэмдэг, тэмдэглэгээг сэргээх, шинээр 25 ширхэг тэмдэг хийлгэх хөрөнгө болон “Номгон”, “Эрдэнэмандал”, “Соого сейко” сургуулийн орчмын замуудад хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээ хийлгэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлснээр хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлсэн байна.

1.1.3 Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт хэрхэн тогтоож байна вэ?

Тус аймгийн Цагдаагийн газар нь давтан гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд холбогдох заавар журмын дагуу захиргааны хяналт тавьж ажиллаж байна.

Тус аймгийн Цагдаагийн газар 2017 оны эхэнд захиргааны хяналтанд 65 этгээд байснаас хугацаа дууссан үндэслэлээр 18 хүний хяналтыг зогсоож, 49 этгээд шинээр хяналтанд орж, одоо нийт 98 хүнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Улсын ерөнхий прокурорын 2015 оны №А/89 тушаалаар батлагдсан “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын заавар”, Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны №А/05, А/09 тоот тушаалаар батлагдсан “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”-ын дагуу захиргааны хяналт тогтоон ажиллаж байна.

Шүүхээс хорих ялыг тэнссэн, хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд тавих захиргааны хяналтыг Цагдаагийн байгууллагаас хэрхэн хэрэгжүүлж байгаад тус аймгийн Прокурорын газраас 2017 оны нэгдүгээр улирлын байдлаар, Улсын ерөнхий прокурорын газраас ирүүлсэн удирдамжийн дагуу “Хорих

ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан болон хорих ял нь тэнсэгдсэн ялтны ял эдлэлтэд Цагдаагийн байгууллагаас хяналт тавьж буй байдал"-д 2017 оны эхний 4 сарын байдлаар шалгалт хийжээ.

Цагдаагийн газрын олон нийттэй харилцах албаны ахлах байцаагч Шүүхээс ирүүлсэн ялтны хувийн хэргийг хүлээн авч, дардас дарж, хүлээн авсанаас хойш 7 хоногт багтаан захиргааны хяналт тогтоох тогтоол үйлдэн, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгчид шилжүүлж хэвшжээ. Хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нар захиргааны хяналтанд байгаа этгээдүүдтэй сар бүр уулзан, ялтанд хууль, шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг бичгээр танилцуулж, уулзалтын тэмдэглэл хөтөлж, түүний засрал хүмүүжилд хяналт тавин, гэмт хэрэг, зөрчилд дахин холбогдохгүй байх талаар зөвлөгөө өгч, баталгаа гаргуулан авч, хувийн хэрэгт нь баяжилт хийн ажиллаж байна.

Аймгийн Прокурорын газрын 2017 оны II улирлын ажлын төлөвлөгөөний дагуу шүүхээс хорих ялыг тэнссэн, хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан ялтанд тавих захиргааны хяналтыг Цагдаагийн байгууллагаас хэрхэн хэрэгжүүлж байгаад хийсэн шалгалтаар 7 төрлийн зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулахаар шаардлага хүргүүлж ажилласан ба үүний дагуу зөрчлийг бүрэн арилгаж, зөрчил гаргасан гурван албан хаагчид сахилгын шийтгэл тус тус ногдуулжээ.

2017 оны эхний 4 сарын байдлаар захиргааны хяналтанд байгаа ялтнуудаас захиргааны хяналтаас зайлсхийсэн 1 этгээд байсан бөгөөд түүнийг эрэн сурвалжлах ажиллагаа явуулж олсон байна.

Захиргааны хяналтанд байгаа тэнсэгдсэн ялтнуудаас 3 ялтан гэмт хэрэг үйлдсэн тул хорих ялаар шийтгүүлсэн байна. Тэнсэгдсэн ялтнууд захиргааны зөрчил гаргасан, эсэх талаархи лавлагааг Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас сар бүр авч ажиллаж байгаа ба 2017 онд 2 ялтан тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон тул Сум дундын эрүүгийн хэргийн шүүгчийн шийтгэврээр нэр бүхий 2 этгээдэд баривчлах шийтгэл ногдуулж, хорих ялыг нь биечлэн эдлүүлэхээр болжээ.

2017 оны IV сарын 24-нд аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газрын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу шүүхээс хорих ялыг тэнссэн, хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан, ял хойшлогдож захиргааны хяналт тогтоогдсон 74 ялтанд сургалт зохион байгуулсан ба Цагдаагийн газраас Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар, Хүний

эрхийн үндэсний комиссын мэргэжилтэн Б.Содонцэцэг “Хүний эрх”, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Г.Сайханцэцэг, Н.Одгэрэл нар “Ажил мэргэжлийн чиг баримжаа”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр” сэдвүүдээр сургалт явуулж, гэмт хэрэг, түүний үр дагаврыг харуулсан богино хэмжээний кино үзүүлжээ.

Аудитын явцад захиргааны хяналтанд байгаа 98 хүний хувийн хэрэгтэй биечлэн танилцахад бүх ялтны хувийн хэрэгт иргэний үнэмлэхний хуулбар, ялтны гар, хурууны хээний дардас, биеийн шарх, сорви, шивээс гэх мэт содон тэмдэг зэргийг тусгайлан тэмдэглэж, ялтанд оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан шүүгчийн захирамж, шүүхийн шийтгэх тогтоолыг хавсарган, ялтны засрал хүмүүжлийн талаархи тодорхойлолтыг оршин суугаа болон ажлын газраас авч байна. Шүүхээс тогтоосон хяналтын хугацаа дуусмагц энэ талаар шүүхэд болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэж хэвшсэн байна.

1.1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг хэрхэн татан оролцуулж байна вэ?

Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь дан ганц хууль сахиулах байгууллагуудын үүрэг биш бөгөөд “Олон нийтийн хүчинд түшиглэх” зарчмын дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж байна

Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийг үндэслэн 28 иргэнийг олон нийтийн цагдаагаар ажиллуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах үүрэг гүйцэтгүүлж байгаа ба тэдэнд сард 300,0 мянган төгрөгийн урамшуулал олгож байна. Олон нийтийн цагдаа нар 2016 он, 2017 оны эхний хагаст 18 гэмт хэрэг, 246 зөрчил илрүүлжээ.

Дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Тус аймагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Малчдын бүлэг 96, Өсвөрийн сэргийлэгчдийн бүлгэм 24, 14 сургуульд эцэг эхийн эргүүл үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд 2412 иргэн хамрагдсан ба Цагдаагийн байгууллагаас дээрх бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд 131 удаа зөвлөмж өгч, хамтран ажиллаж байна.

- Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

зорилгоор Бууцагаан сум дахь сум дундын Цагдаагийн хэсгээс хариуцсан сумын сургуулийн “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн сурагчидтай хамтран “Архигүй ирээдүйн төлөө хамтдаа” уриалга гаргаж, “Аав, ээжүүд ээ! Согтуу байхыг чинь хармааргүй л байна шүү” уриалга гаргаж, эцэг, эхчүүдэд танилцуулж, тэднээр гарын үсэг зуруулан ажиллаж байна.

- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 33 дугаар тогтоолоор мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мал сүргийг хамгаалах зорилго бүхий “Малчдын бүлэг ажиллуулах журам”-ыг хэлэлцэн баталсан ба уг журмыг сумдын ГХУСАЗЗ-д хүргүүлэн, цагдаагийн байгууллагаас удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласнаар сумдад 96 малчдын бүлэг байгуулагдаж, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасгаас “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх аймгийн тэргүүний малчдын бүлэг” шалгаруулах болзолт уралдааны удирдамжийг боловсруулан батлуулж, удирдамжийг сумдын ГХУСАЗЗ-д хүргүүлсэн байна.

- Аймгийн Цагдаагийн газраас явган зорчигч нарыг хөдөлгөөний аюулгүйбайдлын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, жолооч болохоор суралцаж байгаа хүмүүст явган зорчигч нарт зам тавьж өгч байх дадал эзэмшүүлэхийн тулд авто жолооны сургуулиудад суралцаж байгаа сонсогчдийг аймгийн төвийн сургууль орчим болон явган зорчигчдийн гарц дээр, тодорхой цагуудад (хичээл орох, тарах, өдрийн ундны үеэр) зогсоон хамтран ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр “Төрийн албыг архигүйгээр гүйцэтгэе” уриалга гаргаж, Баянхонгор аймгийн төрийн бүх байгууллагад хүргэж, ажлын байранд, ажлын цагаар архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байхыг уриалж, төрийн албан хаагчдаас бичгээр баталгаа авчээ.

1.1.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт үр дүнтэй зохион байгуулагдаж байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт үр дүнтэй зохион байгуулагдаж байна.

Аймгийн ГХУСАЗЗ-өөс 2016 онд “Хуулиа дээдэлье” аяны хүрээнд хуулийн байгууллагуудтай хамтран “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь иргэн бүрийн үүрэг мөн” уриан дор нээлттэй өдөрлөгийг бүх сумдад зохион байгуулжээ.

Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Шүүхийн тамгын газар, Прокурорын газар, Өмгөөлөгчдийн холбоотой хамтран гэмт хэргийн гаралт нэмэгдэх хандлагатай байгаа Бууцагаан суманд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсгээр мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, Шүүхэд шилжүүлсэн А нарын 10 хүнд холбогдох эрүүгийн хэргийн нээлттэй шүүх хуралдааныг хийсэн байна. Энэ үеэр хууль сахиулах байгууллагын ажилтнууд тус сумын иргэдэд сургалт явуулж, зөвлөгөө өгч, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн байна.

Баянхонгор аймаг дахь шүүхүүд, Шүүхийн тамгын газраас Монгол улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль / Шинэчилсэн найруулга / хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дээрхи хуулиудыг сурталчилж, иргэдийн сонирхсон асуултанд хариулж, гарын авлага, брошюр бэлтгэн тараажээ.

Хорт зуршлын бие хүн, гэр бүл, нийгэмд үзүүлэх уршиг, хор нөлөөг таниулах, хорт зуршлаас хүүхэд, өсвөр үеийнхнийг урьдчилан сэргийлэх, архи, тамхины хэрэглээний эсрэг хамтдаа тэмцэх зорилгоор Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын ОНХХ-тэй хамтран “Хорт зуршлын эсрэг нэгдэгцгээе – 2017” сарын аяныг зохион байгуулж, мэдээлэл сурталчилгааны ажлууд хийсэн байна. Архины хор хөнөөлийг сурталчилсан богино хэмжээний шторк болон анхааруулгыг аймгийн Цагдаагийн газрын Facebook хуудас болон цахим сайтад байршуулан, орон нутгийн 3 телевизээр тогтмол нэвтрүүлж ажилласан байна. Аймгийн ГХУСАЗЗ, Улаанбаатар хотын “Зөвлөх үйлчлэл” ТББ-тай хамтран Баянхонгор сумын 1-9 дүгээр багт оршин суух архины хамаарал бүхий 30 иргэнд “Эдгэрлийн баяр хөөр” нэртэй тэдний зан үйлд нөлөөлөх 3 өдрийн сургалт зохион байгуулжээ.

Аймгийн Цагдаагийн газраас Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газартай хамтран 2017. 05. 31-нд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, түүнийг худалдан борлуулдаг болон тамхи худалдаалах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд архи, тамхины хор хөнөөлийг сурталчилсан тараах материал, зурагт хуудсуудыг байршуулсан байна.

Цахим тоглоомд бага насны болон өсвөр насны хүүхдүүдийг донтохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 274 хүнсний дэлгүүр, 33 эмийн сан, ерөнхий боловсролын 5 сургуульд 3 төрлийн сэрэмжлүүлэг байршуулж, олон нийт, иргэдэд анхааруулж ажиллажээ.

Цагдаагийн газрын bayankhongor.police.gov.mn сайт болон фэйсбүүк хуудсанд интернет орчинд гарч буй гэмт хэрэг, эрсдэлийн талаар мэдээлэл байршуулж, “Цэнхэр халим” тоглоомын хор хөнөөлийн талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Политехник коллежийн оюутнуудад сэрэмжлүүлэг бэлтгэн тараажээ.

ГХУСАЗСЗ, Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн ОНХХ-1, Дэлхийн зөн ОНХХ-2 хамтран “Хуулиа дээдэлье” аяны хүрээнд “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэн бүрийн оролцоо” сэдэвт “Дэвжээ” тэмцээнийг 2017 онын 2 дугаар сард ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, сурагчид, эцэг эхийн төлөөллийг оролцуулан зохион байгуулжээ. Мөн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран “Зам тээврийн ослоор хохирсон хүүхэд”-ийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 6 сургууль, 13 цэцэрлэгийн удирдлагууд, нийгмийн ажилтан, багш, эцэг эх, сурагчдын төлөөллийг оролцуулсан сургалт-хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг сонсон, аймгийн төвийн ерөнхий боловсролын бүх сургууль, цэцэрлэгийн орчныг “Хүүхдэд ээлтэй аюулгүй орчин” бүрдүүлэх төлөвлөгөө гарган ажиллахаар шийдвэрлэсэн байна.

Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран “Ногоон гэрэл-цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнийг жил тутам зохион байгуулсанаар бага насны хүүхдүүд, сурагчид зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдлэгтэй болж байна.

1.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна.

1.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна уу.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.

Цагдаагийн газраас малын хулгайн гэмт хэрэг үйлддэг болон үйлдэж болзошгүй этгээдүүдийн судалгааг шинэчлэн, 98 хүнийг хамруулж, сэжигтэй этгээдийн зураг, хань хамсаатан, малын тоо, нутагладаг газар, очиж болзошгүй хаяг, утасны дугаар, тээврийн хэрэгсэлийн марк, улсын дугаар зэргийг багтаасан мэдээллийн сан байгуулан, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлэн, тэдний үйл

хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна. Мөн малын шүд, им, тамга, зүсний нэршлийн талаар зурагт тайлбар хийн, мал хулгайлах гэмт хэргийн газрын үзлэг хийх, малын хулгайн гэмт хэргийн хохирогч, холбогдогч нарт тавих асуултын загвар, аргачлалыг гарган CD-нд буулган хувилж, сумдын хэсгийн төлөөлөгч нарт тараан өгч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн сар бүрийн мэдээнд үндэслэн гэмт хэргийн гаралт өссөн сум, баг дээр урьдчилан сэргийлэх ажлыг бусад хэсгийн байцаагч нартай хамтран ажиллаж байна. Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлыг эрчимжүүлэх аян зохиосон. Аймгийн төвд хэсгийн байцаагч нар багийн цагдаа, олон нийтийн цагдаа нарын хамт баг дээрээ идэвхтэй ажиллаж, иргэдтэй уулзаж, яриа таниулга хийж, объектын судалгаандаа баяжилт хийн, хариуцсан нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэж байна. Эргүүлийг чанаржуулахад анхаарч ажиллаж байгаа ба цагдаа нарыг эргүүлд гарахад нь өдөрт 2-3 хаягаар явуулж, сэжигтэй этгээдүүдэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн багуудын гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, хулгай хийдэг болон сэжигтэй этгээдүүдийн судалгааг нэгтгэж, цагдаагийн алба хаагчдад мэдээлэл өгч ажиллаж байна. Өмчийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сурталчилгааг орон нутгийн TV, худалдааны төвүүдийн узель, урсдаг самбараар тогтмол хийж байна. Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдад удирдамж хүргүүлж ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил дээр анхаарч ажиллажээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон түүнийг дагаж гарсан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”, “Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам”-аар Цагдаагийн газрын 120 албан хаагчид 8 цагийн сургалт зохион байгуулж, хуулийг нэг мөр хэрэглэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан байна.

1.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоо болон давхардсан, орхигдуулсан чиг үүргүүд байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, давхардсан болон орхигдуулсан чиг үүргүүд байхгүй байна.

Төрийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи чиг үүргийг тус тусын хуулиар зохицуулж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нэгтгэн зангидаж, Улсын Их Хурал, бүх шатны ИТХ-аас бодлого чиглэлийг тодорхойлон өгч, төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан батлаж, Засгийн газар болон бүх шатны Засаг дарга нар төрийн

гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч субъектийн хувьд Монгол улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх талаархи төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайн, давхардсан болон орхигдуулсан чиг үүргүүд байхгүй байна гэж үзлээ.

1.2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа үр дүнтэй байна уу?

Аймгийн болон сумдын ГХУСАЗЗ-үүд нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сайн зохион байгуулж, үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлж байна.

Баянхонгор аймгийн ГХУСАЗСЗ нь 2015-2017 онд иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ ажилд хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулах зорилт дэвшүүлэн ажиллаж, тайлангаа жил тутам Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 115 тоот тогтоолоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг 17 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж байна.

2015 онд тус аймгийн 104 багт ГХУСАЗСЗ-ийн гишүүд, хууль, хяналтын байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсэг эрх зүйн сургалт явуулж, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгчээ.

Тус аймгийн ГХУСАЗСЗ, Хуульзүйн хэлтэс, Цагдаагийн газар хамтран “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд бүс нутгийн хамтын ажиллагаа” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг Баянхонгор аймагт 2015 оны 4-р сард хийж, Хууль зүйн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, ЦЕГ-ын төлөөлөл, 7 аймгийн ИТХ-ын дарга, Цагдаагийн газрын удирдлагууд болон холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулжээ. Энэхүү зөвлөгөөний үеэр мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор бод малд микро чип суулгах ажлыг Баянхонгор аймагт хэрэгжүүлж эхэлж байгаа талаар зөвлөгөөнд оролцогчдод танилцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга нар 2015 онд Дархан-Уул аймгийн Дархан сум, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ИТХ, ГХУСАЗСЗ-ийн ажлын туршлага, ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотын

Их Хурлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баримтлаж буй бодлого чиглэл, үйл ажиллагаатай танилцсан байна.

ГХУСАЗСЗ-ийн хурлаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон иргэний хяналт тавих чиг үүрэг бүхий “Иргэний зөвлөл”-ийн тайлан сонсголыг хэлэлцэж, тус зөвлөлийн дарга, гишүүдэд ажлаа эрчимжүүлэх үүрэг чиглэл өгчээ.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс санаачлан 2016 оноос хойш аймгийн хэмжээнд “Залуу гэр бүлийн чуулган”-ыг “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвийн хүрээнд зохион байгуулсан нь залуу гэр бүлийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлийн талаар аймгийн хэмжээнд баримтлах бодлого чиглэлийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг оновчтой тодорхойлох, гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурахтай тэмцэх хууль тогтоомжийг сурталчлах талаар ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

“Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нийгмийн түншлэлийн багийн ажлын үр дүн, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” аймгийн III зөвлөгөөнийг аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ холбогдох байгууллагуудтай хамтран 2016 оны 4 дүгээр сард зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл 180 хүн оролцжээ. Зөвлөгөөнөөр гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи нийгмийн түншлэлийн багийн ажлын үр дүнг дүгнэн, цаашдын ажлын чиглэлээ тогтоосон байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс түүхч, доктор Д.Өлзийбаатарыг урьж, ерөнхий боловсролын сургуулийн 7-12 дугаар ангийн сурагчид, Политехник коллежийн оюутнууд болон төрийн албан хаагчдад зориулан “Эх түүхээрээ бахархъя”, “Монголчууд бид яагаад түүхээ судлах ёстой вэ?” лекц уншуулсан нь оролцогчдод танин мэдэхүйн болон өвөг дээдсээрээ бахархах, эх оронч үзэл төлөвшүүлэх ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга Ц.Отгонбаяр, аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Оюутболд нар 2016 онд Япон улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай танилцжээ.

Аймгийн Прокурорын газраас “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь иргэн бүрийн үүрэг мөн” уриан дор тус аймгийн Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдад нээлттэй хаалганы өдөрлөгийг 2017 оны 5 дугаар сард зохион байгуулж, аймгийн прокурор Ж.Уранцэцэг нэр бүхий 3 сумын ГХУСАЗСЗ-ийн ажлыг биечлэн шалгаж, зөвлөгөө өгч, шалгалтын дүнгийн талаар аймгийн ГХУСАЗСЗ-д танилцуулжээ.

Аймгийн ГХУСАЗСЗ 2017 онд иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах болон зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт, арга хэмжээг нэгдсэн бодлогоор зохион байгуулж, энэ ажилд иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор “Амар тайван Баянхонгор” зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ-өөс сумдын салбар зөвлөлийн дарга нарт эрх зүйн сургалтыг ажлын хэсэг гарган, бүсчилэн зохион байгуулжээ.

Баянхонгор аймгийн бүх сумдад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл байгуулагдан, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн салбар зөвлөлийн тайлангаас үзэхэд сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжсон бөгөөд жилийн ажлын төлөвлөгөө гарган, салбар зөвлөлийн хурлаар шаардлагатай асуудлаа хэлэлцэн шийдвэрлэж, багийн иргэдэд хүрч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил арга хэмжээг сайн зохион байгуулж ажиллаж байна.

Дээр дурдсан гол ажлуудаас дүгнэлт хийхэд аймгийн болон сумдын ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүн нь боловсрол, мэргэжил, төрийн ажлын дадлага туршлагын хувьд харилцан адилгүй хүмүүс байгаа, салбар зөвлөлүүд нь Орон тооны бус байгууллага боловч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж, энэ ажлыг сайн зохион байгуулж, үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлж байна.

1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх.

1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас зориулалт бусаар зарцуулагдаж байна.

1.3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө хуульд заасан хэмжээнд төлөвлөгдөж байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хуульд заасан хэмжээнд төлөвлөөгүй байна.

2015 онд шүүхийн шийдвэр биелүүлэх үйл ажиллагаанаас 4.0 сая төгрөг, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого

болгосон, торгох ял ногдуулсан 160.0 сая төгрөг төсөвт төвлөрсний 49,5 хувь буюу 60.0 сая төгрөгийг, 2016 онд шүүхийн шийдвэр биелүүлэх үйл ажиллагаанаас 5.6 сая төгрөг, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулсан 209,8 сая төгрөг төсөвт төвлөрсний 38,1 хувь буюу 80.0 сая төгрөгийг, 2017 онд шүүхийн шийдвэр биелүүлэх үйл ажиллагаанаас 18.9 сая төгрөг, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулсан 214,1 сая төгрөг төсөвт төвлөрсний 37,3 хувь буюу 80.0 сая төгрөгийг тус тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна.

Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалтын хэмжээнд төлөвлөөгүй байна. Энэ нь орон нутгийн төсөв хүрэлцэхгүй байгаатай холбоотой байна.

1.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт холбогдох хуулиудад нийцэж байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас хөрөнгө бэлтгэх болон зарим байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэн зориулалт бусаар зарцуулж байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйлийн 19.4 дэх заалтыг зөрчжээ.

2015 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 60.0 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 53,6 сая төгрөг, 2016 онд 80.0 сая төгрөг батлагдаж бүрэн, 2017 онд 80.0 сая төгрөг батлагдаж эхний хагас жилийн байдлаар 35.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйлийн 1-т зааснаас өөр эх үүсвэрээс санхүүжилт хийгдээгүй байна.

Аудитаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг анхан шатны баримттай тулгаж үзэхэд дараах зөрчлүүд илрэв.

2015 онд “Хонгор нутаг” зургийн альбомны үнэ 5250.0 мянга, бэлэг дурсгалын торны үнэ 510.0 мянга, ИТХ-ын даргын гар утасны төлбөр 257.7 мянга, адуучин тэмцээнд оролцсон малчдад тараасан “Миний адуун сүрэг” хуурцаганд 1000.0 мянган төгрөг, компьютер техник хэрэгслэл бэлтгэхэд 5617.0 мянга, ИТХ-ын ажлын

албаны тайлан бэлтгэхэд 320.0 мянга, нийт 12954.7 мянган төгрөгийг тус бүр зориулалт бусаар зарцуулсан.

2016 онд түүхийн ухааны доктор Д.Өлзийбаатарын бүтээл “Монголчууд” сонсдог CD-нд 6440.0 мянга, Цагдаагийн байгууллагын 95 жилийн ойн цагдаагийн ажилчдын хангайн бүсийн урлаг спортын наадам зохион байгуулах зардал 1000.0 мянга, ИТХ-ын ажлын албаны автомашины засварын хөлс, тээврийн хөлсөнд 1950.0 мянга, Ахмадын чуулган зохион байгуулах зардалд 1000.0 мянга, Шүүхийн шинжилгээний албанд зөөврийн компьютер авахад 500.0 мянга, ИТХ-ын ажлын албанд өнгөт принтер худалдан авахад 1650.0 мянга, нийт 12540.0 мянган төгрөгийг зориулалт бусаар, Залуу гэр бүлийн чуулга уулзалтын зардал 9600.0 мянга, “Гэр бүлийн үнэ цэнэ” чуулганы арга хэмжээний зардал 4789.1 мянга, МХГ-тай хамтран зохион байгуулсан “Эмийн зохистой хэрэглээ” аяны 2000.0 мянга нийт 14389,1 мянган төгрөгийн анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн.

2017 онд Баруун бүсийн туршлага судлах үеэр бэлэг дурсгалын зүйлд 724.0 мянга, Соёрхол тэмдэг хэвлүүлэх зардал 490.0 мянга, 3 хүнд цалингийн урьдчилгаа 950.0 мянга, Аймгийн цагдаагийн газрын үйл ажиллагааны тайлан сэтгүүлийн үнэ 2100.0 мянга, Зохицуулах зөвлөлийн ажлын албанд компьютер худалдан авахад 1000.0 мянга, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэст интернетийн төлбөр 1000.0 мянга нийт 6246.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Баян-Өлгий аймагт "Нутгийн өөрөө удирдах байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ хэрэгжүүлэх нь" зөвлөгөөнд оролцох зардлын 2224.0 мянга, Нэгэн дээвэр дор тэмцээний үеэр хууль суртчилах арга хэмжээний 126.0 мянга, Заг суманд болох зөвлөгөөнд оролцогчдод эрх зүйн сургалтын 242.0 мянга, Уяач хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах ажлаар УИХ-ийн гүйшүүн Д.Гантулгад хүндэтгэл үзүүлэх зардлын 774.0 мянга нийт 3366.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Аудитад хамрагдсан 2015, 2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийтдээ 31740.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-д заасан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно”, 17755,1 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул зориулалт бусаар зарцуулсан

зөрчлийг цаашид зогсоох, баримтын бүрдэл дутуу 17755.1 мянган төгрөгийн анхан шатны баримтыг холбогдох хүмүүсээс авч бүрдүүлэн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

1.3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулсан төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдахгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байгаа эсэхийг аудитад хамрагдаж байгаа хугацааны гэмт хэргийн тоонд уялдуулан авч үзэхэд 2015 онд гэмт хэргийн тоо 360 байсан бөгөөд 2016 онд 356 буюу 4 хэргээр буюу 1.1 хувиар буурсан боловч 2017 оны эхний хагас жилийн байдлаар 212 гэмт хэрэг гарсан байгаа нь 2016 оны мөн үеийнхтэй харьцуулахад 34 хэргээр буюу 19.1 хувиар гэмт хэргийн тоо өссөн байна.

Дээрх статистик тоон үзүүлэлт болон зориулалт бусаар зарцуулж байгаа байдлаас дүгнэж үзэхэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулж байгаа хөрөнгө нь үр ашиг муутай зарцуулагдаж байна.

1.3.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрхэн явагдаж байна вэ?

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ИТХ хяналтаа бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалт, ажлын үр дүнгийн талаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хурлаар тайлан авч хэлэлцэн дүгнэж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтыг аймгийн ИТХ-д тайлан болгож тусгайлан танилцуулаагүй байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйлийн 19.5-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Баянхонгор аймгийн төрийн болон хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцлийг арилгах талаар хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч Бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхай, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргүүд өсөх хандлагатай байна.

2. Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын Судалгаа, дүн шинжилгээний баг 2015, 2016 онд тус бүр 4 удаа, 2017 оны эхний хагас жилд хэсгийн байцаагч, багийн цагдаа, эрүүгийн төлөөлөгч нарыг оролцуулан өргөтгөсөн байдлаар 6 удаа хурал хийж, гэмт хэргийн гаралт, анхаарах асуудлын талаар багийн гишүүд санал бодлоо илэрхийлж ярилцаж байгаа боловч гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тогтоох талаар Судалгаа, дүн шинжилгээний баг хангалтгүй ажилласан байна.

3. Бүх шатны ИТХ, нутгийн захиргааны байгууллага гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

4. Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар нь давтан гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан, хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд холбогдох заавар, журмын дагуу захиргааны хяналт тавьж ажиллаж байна.

5. Баянхонгор аймгийн Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи хууль тогтоомжийг сурталчлах талаар хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллаж байна.

6. Аймгийн болон сумдын ГХУСАЗСЗ-үүд нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сайн зохион байгуулж, хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаж байна.

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга, ГХУСАЗЗ-ийн дарга Ц.Отгонбаяр танаа

1. Нийтийн эзэмшлийн зам, талбай, орон сууц, гэр хорооллын гудамжийг дүрс бичлэгийн техник хэрэгсэлээр бүрэн хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, хяналтын камерт урсгал засвар хийлгэх хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэж байх.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, ажлын албанаас тавих хяналтыг сайжруулж, зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоох.

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Оюутболд танаа

1. Цагдаагийн газрын Судалгаа, дүн шинжилгээний баг гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцлийг тогтоох үүргээ биелүүлж ажиллах.
2. Аймгийн нутаг дэвсгэрт зонхилон үйлдэгдэж буй тодорхой төрлийн гэмт хэрэг (Бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхай, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг)-ийн гаралтыг бууруулах ажлыг үр дүнд хүргэх.
3. 2017 оны эхний хагас жилд 5162 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37 хувиар өссөн байгаа тул үүнд онцгой анхаарч ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажил, хүрсэн үр дүнгийн талаар 2018 оны 03 дугаар сарын 15-ны дотор манай байгууллагад албан ёсоор хариу ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

Баянхонгор аймагт гарсан гэмт хэргийн судалгаа

/ 2015-2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар /

Хавсралт № 1

№		Хамарсан хугацаа								
		2014 он	2015 он	Хувь / Өсөлт +, Бууралт - /	2015 он	2016 он	Хувь / Өсөлт +, Бууралт - /	2016 оны э/х жил	2017 оны э/х жил	Хувь
1	Гэмт хэрэг	430	360	-16,3	360	356	-1,1	194	212	9,3
Үүнээс	Хөнгөн	185	169	-8,6	169	180	6,5	86	98	14,0
	Хүндэвтэр	207	158	-23,7	158	159	0,6	98	96	-2,0
	Хүнд	28	29	3,5	29	12	-58,2	6	15	1,5 дахин
	Онц хүнд	10	4	-60,0	4	5	25,0	4	3	-25,0
Хэргийн өнгө	Хүн амь	6	1	- 83,3	1	4	3 дахин	3	2	-33,3
	ББМГэмтэл учруулах	135	132	-2,2	132	137	3,7	58	80	38,0
	Мал хулгайлах	36	36	0	36	30	-16,6	25	19	-24,0
	Иргэдийн өмчийг хулгайлах	86	76	-11,6	76	85	11,8	50	39	-22,0
	Залилан	4	5	25,0	5	6	20,0	1	8	7 дахин
	Танхай	19	13	-31,5	13	5	-61,5	5	12	1,4 дахин
	ХАБЭсрэг гэмт хэрэг	48	22	-54,1	22	20	-9,0	7	11	57,1
2	Илрүүлэлт / Хувиар /	69,5	71,3	1,8	71,3	74,4	3,1	63,0	71,0	8,0
3	Илрээгүй хэрэг	18	25	38,8	25	30	20,0	30	18	-40,0
4	Холбогдогч	499	401	-19,6	401	377	-5,9	193	234	21,2
5	Согтуугаар үйлдсэн	144	114	-20,8	114	121	6,1	60	56	-6,6
6	Хохирсон хүн, байг-га	418	386	-7,6	386	368	-4,6	194	224	15,4
7	Хохирол / Сая төг /	682,9	496,2	-27,3	496,2	700,6	41,2	382,2	410,0	7,2
8	Хохирол нөхөн төлүүлэлт	440,4 буюу 64,4 хувь	344,5 буюу 69,4 хувь	5,0	344,5 буюу 69,4 хувь	536,6 буюу 76,6 хувь	7,2	269,9	273,4 буюу 66,6 хувь	3,5
9	Нас барсан	29	12	-58,6	12	27	1,2 дахин	9	12	33,3
10	Гудамж талбайд	78	70	-10,2	70	59	-15,7	29	42	44,8
11	Гэр, орон сууцанд	144	112	-22,2	112	161	43,7	96	70	-27,0